Байгууллагын "Ес зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн биелэлт


Архангай аймаг

Д/д	Агентлаг, байгууллагын нэр	Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	10	6	60
2	Байгаль орчны газар	10	4,5	45
3	Биеийн тамир, спортын газар	10	5,5	55
4	Боловсролын газар	10	5,5	55
5	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	10	4,5	45
6	Мал эмнэлгийн газар	10	5,5	55
7	Музей	10	5,5	55
8	Нийтийн номын сан	10	6,5	65
9	Орон нутгийн газар	10	5	50
10	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	10	5	50
11	Хөгжимт драмын театр	10	5,5	55
12	Худалдан авах ажиллагааны газар	10	5,5	55
13	Хүнс, хөдөө аж ахуйн газар	10	4	40
14	Эрүүл мэндийн газар	10	6,5	65
15	Батцэнгэл сумын Засаг даргын тамгын газар	10	5,9	59
16	Булган сумын Засаг даргын тамгын газар	10	6	60
17	Жаргалант сумын Засаг даргын тамгын газар	10	8	80
18	Ихтамир сумын Засаг даргын тамгын газар	10	7,5	75
19	Өгийнуур сумын Засаг даргын тамгын газар	10	5,2	52
20	Өлзийт сумын Засаг даргын тамгын газар	10	7	70
21	Өндөр-Улаан сумын Засаг даргын тамгын газар	10	7	70
22	Тариат сумын Засаг даргын тамгын газар	10	6,5	65
23	Төвшрүүлэх сумын Засаг даргын тамгын газар	10	6,5	65
24	Хайрхан сумын Засаг даргын тамгын газар	10	6,5	65
25	Хангай сумын Засаг даргын тамгын газар	10	5,5	55
26	Хашаат сумын Засаг даргын тамгын газар	10	7	70
27	Хотонт сумын Засаг даргын тамгын газар	10	5	50
28	Цахир сумын Засаг даргын тамгын газар	10	7	70
29	Цэнхэр сумын Засаг даргын тамгын газар	10	2,5	25
30	Цэцэрлэг сумын Засаг даргын тамгын газар	10	6,5	65
31	Чулуут сумын Засаг даргын тамгын газар	10	7,5	75
32	Эрдэнэбулган сумын Засаг даргын тамгын газар	10	6,5	65
33	Эрдэнэмандал сумын Засаг даргын тамгын газар	10	7,5	75
Үнэлгээний дундаж оноо, хувь		**10**	**5,94**	**59,4**


Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга
Аймгийн Засаг даргын тамгын газрын Ёс зүйн дэд хороо аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн А/35 дугаар тушаалаар 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 13 агентлаг, 19 сумын Засаг даргын тамгын газар, нийт 32 байгууллага Ёс зүйн дэд хороогоо 3-5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан бөгөөд 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлан, хэрэгжүүлж ажилласан байна. Дээрх байгууллагуудаас ирүүлсэн тайлан, мэдээг нэгтгэж үзэхэд тайлант онд 5 байгууллагын ёс зүйн дэд хороонд ирүүлсэн 9 гомдол, мэдээллийг хянан шалгаж үзээд, үүнээс 4 гомдол, мэдээллийг ёс зүйн зөрчил гаргасан гэж дүгнэсэн байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
Байгууллагын ёс зүйн дэд хороод үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг зохион байгуулж, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн албан хаагчид ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж, зааврааар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг бүрдүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, дүрмийг сурталчлан таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх, албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал, төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэг, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шударга, ил тод төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор ёс зүйн дэд хороодоос тайлант онд сургалт, өдөрлөг зохион байгуулах, санамж, зөвлөмж боловсруулж хүргүүлэх, дотоод сүлжээ, самбараар мэдээлэл, товхимол хүргүүлэх, тэмцээн уралдаан зохио байгуулах зэрэг ажлыг зохион байгуулж, ёс зүйн 77 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 1796 төрийн албан хаагчийг хамруулжээ.









2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Байгууллагын ёс зүйн дэд хорооны шийдвэрийг үндэслэн 2 байгууллага 4 шийдвэр гаргаж 4 албан хаагчид хариуцлага тооцсон байна.
Төрийн байгууллагууд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж хэвшсэн.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Ёс зүйн дэд хороодоос байгууллага, салбарын хүрээнд төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах замаар байгууллагын ёс зүйн соёлыг төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг шат дараатай зохион байгуулж, ирүүлсэн өргөдөл, гомдлыг журмын дагуу хянан үзэж холбогдох дүгнэлт, шийдвэрийг гаргасан.
Цаашид ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд хандалтыг сайжруулах, дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнах байдал, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийх, ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах зэрэг арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байгаа.

Гаргасан үр дүн, ололт амжилт:	**Бэрхшээл:**

- Албан хаагчдын ёс зүйн талаарх мэдлэг, хариуцлага дээшилсэн - Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо сайжирсан - Байгууллагын ёс зүйн соёл төлөвшихөд бодитой өөрчлөлт гарсан - Ёс зүйн зөрчил буурсан	- Ёс зүйн дэд хорооны гишүүд үндсэн ажлынхаа хажуугаар үүрэг гүйцэтгэдэг тул ёс зүйн асуудалд зарцуулах цаг, боломж хязгаарлагдмал, урамшуулал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй, шийдэгдэхгүй байна - Ёс зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол, тасралтгүй зохион байгуулахад төсөв, санхүү, зохион байгуулалтын асуудал - Ёс зүйн зөрчил, эрсдэлийн талаарх мэдээллийг тухай бүр мэдэгдэх, ил тод мэдээлэх соёл бүрэн төлөвшөөгүй байна.

Санал:

- Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмж, мэдээллийг тогтмол хугацаанд боловсруулж, албан хаагчдад хүргэх, соён гэгээрүүлэх ажлыг жил бүрийн төлөвлөгөөнд тусгах.
- Албан хаагчдын ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх зорилгоор сургалт, цахим болон танхимын хэлбэрийг хослуулан зохион байгуулах.
- Ёс зүйн зөрчил, эрсдэлийн талаарх мэдээллийг нууцлалтай, аюулгүй байдлаар хүлээн авах сувгийг тодорхой болгож, албан хаагчдад зөвлөгөө өгөх механизмыг сайжруулах.
- Ёс зүйн (дэд) хорооны гишүүдийн ажиллах нөхцөл, цагийн зохицуулалтыг сайжруулж, шаардлагатай сургалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Б.БОЛОРМАА

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ж.ЭРДЭНЭТУЯА

БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Ж. МӨНХБАТ
2025 оны 01 сарын 20-ны өдөр

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хугацаа /сараар/	Хариуцах эзэн
Нэг: Байгууллагын ёс зүйн дэд хорооноос зохион байгуулах ажил арга хэмжээ.							
1.1	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөг хэлэлцэн баталж, хэрэгжүүлж ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Хувь	1	1	03.01-ны дотор	Нарийн бичгийн дарга М.Тогтохбаяр
1.2	Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хууль, ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Харилцаа, хандлага сургалт зохион байгуулах	Хамрагдсан албан хаагчийн тоо	Тоо	1	3	01, 05, 09 сард	Ёс зүйн дэд хорооны гишүүд Засаг дарга, Тамгын дарга, Орлогч дарга
1.3	Албан хаагчдын сахилга ёс зүйтэй холбоотой иргэдээс ирсэн мэдээлэл, гомдлыг бүртгэх, дүгнэлт боловсруулж гаргах	Өргөдөл, гомдлын тоо Дүгнэлтийн тоо	Тоо	0	-	Тухай бүр	Ёс зүйн дэд хороо
1.4	Шинээр ажилд орсон албан хаагчдад байгууллагад дагаж мөрдөх, дасан зохицох арга хэмжээний талаар бүлгийн, ганцаарчилсан зөвлөгөө өгөх	Дасан зохицох арга хэмжээнд хамрагдах албан хаагчийн тоо	Тоо	2	5	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны гишүүд ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд
1.5	Төрийн захиргааны албан хаагч, үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хууль болон ажлын байранд дагаж мөрдөх	Танилцсан албан хаагчийн тоо	Тоо	0	1	Жилд 1 удаа	Ч. Эрдэнэчимэг

	хэм хэмжээ, заалтуудын талаар албан хаагчдад зөвлөгөө өгөх						
1.6	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухайн хууль, мэдээ мэдээлэл бэлтгэх, постер бэлтгэж түгээх	Мэдээний тоо Постерийн тоо	Тоо	1	2	Тухай бүр	Ш.Мөнхтөр
Хоёр: Бусад байгууллага аж ахуй нэгжтэй хамтран ажиллах нөлөөллийн ажил зохион байгуулах.							
2.1	Дээд шатны ёс зүйн хорооноос зохион байгуулах сургалт, арга хэмжээнд оролцож гишүүдийг чадваржуулах.	Сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулсан эсэх	Хамрагдсан арга хэмжээний тоо	0	1	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, аймгийн ЗДТГ-ын албан хаагчид
2.2	“Хувь хүний ёс зүй ба харилцаа хандлага” сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан эсэх	Хамрагдсан албан хаагчдын тоо	0	1	2025.04 сард	Ёс зүйн дэд хороо, Насан туршийн суралцахуйн төв
2.3	“Бүтээмжтэй цагийг ажилдаа зориулах нь”, “Үг үйлдэлээ анхаарахуй” сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан эсэх	Хамрагдсан албан хаагчдын тоо	0	1	2025.10 сард	Ёс зүйн дэд хороо, Насан туршийн суралцахуйн төв

---ООО---